



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 18.1.2 дахь заалт, Хүүхэд хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.1.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхдийн хөгжил, хамгааллын Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Хүүхдийг замын хөдөлгөөний аюулгүй байдал, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт арга хэмжээг салбарын хэмжээнд харьяа байгууллагуудыг хамруулан зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.

2. “Хүүхдийг замын хөдөлгөөний аюулгүй байдал, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт арга хэмжээний удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Хүүхэд хөгжил, хамгааллын арга хэмжээнд шаардагдах 5,400,000.0 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийг зохих зардлаас гаргаж олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т зөвшөөрсүгэй.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА С БАТБОЛД



080000435

Төрийн нарийн бичгийн даргын  
2022 оны 05 дугаар сарын 27-ны  
өдрийн 159 дугаар тушаалын хавсралт



**“ХҮҮХДИЙГ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ОСОЛ  
ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” АРГА  
ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УДИРДАМЖ**

2022 оны 05 дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**Нэг. Зорилго**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд зам, тээврийн салбарын харьяа байгууллагын албан хаагчид болон эцэг эхийн зөвлөл, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, бага, дунд ангийн сурагчид, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдийг хамруулан замын хөдөлгөөний аюулгүй байдлын анхан шатны мэдлэг олгох, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

**Хоёр. Арга хэмжээг зохион байгуулах хамрах хүрээ**

Харьяа байгууллагын “Эцэг эхийн зөвлөл” болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, бага, дунд ангийн сурагчид, цэцэрлэгийн өмнөх насны хүүхэд, эцэг эх, сурган хүмүүжүүлэгч хамрагдана.

**Гурав. Арга хэмжээ зохион байгуулах хугацаа**

Хүүхдийг замын хөдөлгөөний аюулгүй байдал, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл зохион байгуулна.

**Дөрөв. Арга хэмжээний зохион байгуулалт**

Арга хэмжээг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

1. Харьяа байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн “Хүүхэд хөгжил, хамгаалал”-ын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцүүлж, “Хүүхдийг замын хөдөлгөөний аюулгүй байдал, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон тулгамдсан асуудлыг хэлэлцэх;

2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, бага, дунд ангийн сурагчид, цэцэрлэгийн өмнөх насны хүүхэд, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдийг хамруулсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын анхан шатны мэдлэг олгох, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг өрнүүлж, санамж, сэрэмжлүүлэг түгээх, үзүүлэн сургалт зохион байгуулах;

3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, бага, дунд ангийн сурагчид, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан, зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулж, урамшуулах.

### **Тав. Арга хэмжээний хэрэгжилтийг танилцуулах**

Зам, тээврийн хөгжлийн яамны “Эцэг эхийн зөвлөл” “Хүүхдийг замын хөдөлгөөний аюулгүй байдал, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх” арга хэмжээг зохион байгуулсан талаарх танилцуулгыг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн нарийн бичгийн даргад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөрт багтаан танилцуулна.

---oOo---

